Ковид-19 цар тахлын үед улаан бүсэд ажилласан сувилагч тусгай мэргэжилтний ажлын ачааллыг судалсан нь

Ч.Мандалсайхан[1], Ж.Түмэнжаргал[2], О.Гантуяа[2], О.Мөнхжаргал[1], Х.Зандармаа[1]

[1]АШУУИС, Говь-Алтай АУС
[2]Говь-Алтай Нэгдсэн эмнэлэг
Цахим шуудан: Mandalsaikhan@mnums.edu.mn, Утас: 99747829

Түлхүүр үг:

Сувилахуйн тусламж үйлчилгээ
Асаргаа сувилгаа
Гардан үйлдэл
Сэтгэл зүй

Товч утга:

Үндэслэл: Сувилагч нарын ажлын ачаалал, сувилахуйн тусламж үйлчилгээний чанарт нөлөөлөх нь судалгаагаар 85% нь ажлын ачаалал их, нэг сувилагчид ноогдох эмчлүүлэгчийн тоо их байгаагаас асаргаа сувилгаа хийх цаг гардаггүй зөвхөн хэвтрийн үйлчлүүлэгчид сувилгаа үзүүлж байгаа нь сувилахуйн тусламж үйлчилгээний чанарт сөргөөр нөлөөлөх магадлал өндөр байна гэсэн дүгнэлт гарчээ.[1] Цар тахлын үед дэлхий дахинд эмч сувилагчид улаан бүсэд дундажаар 10-14 хоногоор ажилласан бөгөөд ажлын ачаалал маш их хүний нөөц дутагдалтай байсан. Иймд улаан бүсэд ажилласан сувилагч тусгай мэргэжилтний ажлын ачааллыг судлах шаардлага урган гарч ирж байна. **Зорилго:** Ковид-19 цар тахлын үед Говь-Алтай аймгийн Нэгдсэн эмнэлгийн хэвтэн эмчлүүлэх тасгуудад ажилласан сувилагч нарын ажлын ачааллыг судалж үнэлгээ өгөх. **Арга, аргачлал:** Судалгааг аналитик судалгааны агшингийн загвараа хийсэн ба судалгааны ажлын боловсруулалтыг SPSS-21 программыг ашиглан хийж, судалгааны мэдээллийн өгөгдлийн тархалтыг Колмогоров Смирновын тестээр шалгаж, статистик ач холбогдлын хамаарлыг Спирманы корреляцийн коффициентээр тооцон гаргасан. Нийт судалгаанд хамрагдсан сувилагч тусгай мэргэжилтэнг хүйсээр нь авч үзвэл эмэгтэй 93.1% эрэгтэй 6.9% мэргэжлээр нь авч үзвэл сувилагч 87.4% эх баригч 12.6% нь хамрагдсан байна. Улаан бүсэд ажиллаж байх хугацаанд биед илэрдэг зовиуруудыг авч үзвэл: ядрах-92% толгой өвдөх 63%-д нь илэрч байсан бол, сэтгэл зүйн өөрчлөлтүүдийн хувьд: Айх түгших -81.5% ар гэртээ санаа зовох-59,3% хамгаалах хувцастай олон цаг ажиллах -74% хэцүү үйлчлүүлэгч 89%-г эзлэсэн байна. **Дүгнэлт:** 1. Сувилагч, тусгай мэргэжилтэнүүд улаан бүсэд олон удаагийн дамтамжтайгаар удаа дараалан орж ажиллаж байсан бөгөөд ажиллах хугцаандаа улаан бүс рүү хамгаалалтын хувцас хэрэгсэлтэй олон цагаар сувилахуйн тусламж үйлчилгээг үзүүлж байсан байна. 2. Энгийн болон эрчимт эмчилгээний тасгийн сувилагч нар ажлын цагийнхаа дийлэнх хувийг тариа тарилга, эмчилгээний хуудас, сувилахуйн түүх хөтлөлтөнд асаргаа сувилгаанд хийхэд зарцуулсан байна. 3. Улаан бүсэд ажиллаж буй сувилагч нарын ихэнх хувь нь толгой өвдөх, ядрах ар гэртээ санаа зовох, даралт ихсэх, хэцүү үйлчлүүлэгчтэй ажиллах зэрэг нь эрэг дунд зэргийн хамааралтай байгаа нь тогтоогдсон.

Үндэслэл: Сувилагч нарын ажлын ачаалал, сувилахуйн тусламж үйлчилгээний чанарт нөлөөлөх нь судалгаагаар 85% нь ажлын ачаалал их, нэг сувилагчид ноогдох эмчлүүлэгчийн тоо их байгаагаас асаргаа сувилгаа хийх цаг гардаггүй зөвхөн хэвтрийн үйлчлүүлэгчид сувилгаа үзүүлж байгаа нь сувилахуйн

тусламж үйлчилгээний чанарт сөргөөр нөлөөлөх магадлал өндөр байна гэсэн дүгнэлт гарчээ.[1] Мөнгөн гүүр эмнэлгийн хэвтэн эмчлүүлэх тасгуудын сувилагч нарын ажлын ачаалалд үнэлгээ өгөх" судалгаанд сувилагч нарын хүний нөөц дутагдалтай ч нэг сувилагчид ноогдох үйлчлүүлэгчийн тоо их байгаа нь сувилагч нарын ажлын ачааллыг нэмэгдүүлж байна гэж үзжээ.[2] Монгол улсад корона вируст халдвар 2020 оны 03-р сард бүртгэгдэж, 11-р сард халдвар дотоодод тархан 2022 оны 04 дугаар сарын 6-ны байдлаар 919.625 тохиолдол бүртгэгдсэн байна.[3] Солонгос улсын үндэсний хэмжээнд хийсэн судалгаагаар улаан бүсэд ажиллаж байсан сувилагч нар ерөнхий хийж гүйцэтгэх ажил үүргээсээ гадна 80% нь эмнэлгийн тоног төхөөрөмжийн удирдлага эмнэлгийн ор болон 66.7% нь өрөөг халдваргүйжүүлж цэвэрлэх 33.3% нь үйлчлүүлэгчийн сорьцийг шилжүүлэх, 26.7% нь хоол хүргэх болон үйлчлүүлэгчийг хооллоход туслах үйл ажиллагаа гүйцэтгэж байжээ.[5] Цар тахлын үед дэлхий дахинд эмч сувилагчид улаан бүсэд дундажаар 10-14 хоногоор ажилласан бөгөөд ажлын ачаалал маш их хүний нөөц дутагдалтай байсан талаар олон тооны бүтээлд дурьджээ.

Зорилго: Ковид-19 цар тахлын үед Говь-Алтай аймгийн Нэгдсэн эмнэлгийн улаан бүсэд ажилласан сувилагч, тусгай мэргэжилтний ажлын ачааллыг үнэлэх

Арга, аргачлал: Судалгааг аналитик судалгааны агшингийн загвараар явуулсан бөгөөд судалгааг авахдаа нийт 28 асуумжаар Говь-Алтай аймгийн Нэгдсэн эмнэлгийн улаан бүсэд ажилласан 87 сувилагч, эх баригч нарыг хамруулаа. Судалгааны ажлын боловсруулалтыг SPSS-21 программыг ашиглан хийж, судалгааны мэдээллийн өгөгдлийн тархалтыг Колмогоров Смирновын тестээр шалгаж, статистик ач холбогдлын хамаарлыг Спирманы корреляцийн коффициентээр тооцон гаргасан.

Үр дүн: Судалгаанд хамрагдсан нийт сувилагч тусгай мэргэжилтэнг хүйсээр нь авч үзвэл эмэгтэй 93.1% эрэгтэй 6.9% мэргэжлээр нь авч үзвэл сувилагч 87.4% эх баригч 12.6% ковид-19 халдвар авч өвдсөн байдал 1 удаа өвдсөн 57% 2 удаа өвдсөн 13% огт өвдөөгүй 24% байна. Улаан бүсэд орж ажилсан байдал 1-5 удаагийн давтамжтай орж ажилсан байна 2 удаа 37.9% 1 удаа 32.2% өдөрт улаан бүслүү орж ажилсан давтамж 3 удаа 33.3% 2 удаа 28.7% байв. Ямар хэрэгцээ шаардлагын улмаас ажилласан байдлыг тодруулахад гарах ээлжийн дагуу 34% байгууллагын шийдвэрээр 48% өөрөө хүссэн 18% байна. Өдөрт дундажаар үйлчилж байсан хүний тоо энгийн тасаг 25-аас дээш үйлчлүүлэгчид эрчимт эмчилгээний тасаг 20-иос дээш үйлчлүүлэгчид үйлчлилж байсан байна.

Хүснэгт 1. Гардан асаргаа, сувилгаа - 1

Давтамж	Эм уулгах		Хүчилтөрөгч өгөх		Амин үзүүлэлт	
	Энгийн тасаг	Эрчимт эмчилгээний тасаг	Энгийн тасаг	Эрчимт эмчилгээний тасаг	Энгийн тасаг	Эрчимт эмчилгээний тасаг
1-5 удаа			45%	29.6%		22.2%
6-10 удаа	1.7%		48.3%	63%		55.6%
11-16 удаа	35%		6.7%	3.7%	13%	22.2%
17-24 удаа	63%	71%				
25 дээш		29%		3.7%	87%	

Хүснэгт 1-ээс харахад Эрчимт эмчилгээний тасагт ажиллаж байсан сувилагч нарын 71% нь нэг өдөрт 17-24 үйлчлүүлэгчид эм уулгаж байсан бол, энгийн тасгийн сувилагч нарын 63% нь 25 дээш үйлчлүүлэгчдэд эм уулгаж байсан байна.

Энгийн тасагт ажиллаж байсан сувилагч нарын 48.3% нь нэг өдөрт 6-10 үйлчлүүлэгчид хүчилтөрөгч өгч байсан бол, эрчимт эмчилгээний сувилагч нарын 63% нь мөн нэг өдөрт 6-10 үйлчлүүлэгчид хүчилтөрөгч өгч байсан байна.

Энгийн тасагт ажиллаж байсан сувилагч нарын 87% нь нэг өдөрт 25-аас дээш үйлчлүүлэгчдийн амин үзүүлэлтийг хянаж байсан бол эрчим эмчигээний тасгийн сувилагч нарын 55.6% нь нэг өдөрт 6-10 үйлчлүүлэгчдийн амин үзүүлэлтийг хянаж байсныг дүгнэвэл энгийн тасагтт ажиллаж байсан сувилагч нар илүү ачаалал өндөртэй нь харагдаж байна.

Хүснэгт 2. Гардан асаргаа, сувилгаа - 2


Үзүүлсэн тусламж	Шээлгүүр		Шээлгүүрийн арчилгаа		Уян зүү тавьсан		Уян зүүний арчилгаа	
	Энгийн	Эрчимт	Энгийн	Эрчимт	Энгийн	Эрчимт	Энгийн	Эрчимт
1-5	10%	92.6%	10%	92.6%	43%	40.7%	51.7%	45.7%
6-10	7.4%	4%	7.4%	4%	55%	59.3%	46.7%	54.3%
11-16					1.7%		1.7%	

Хүснэгт 2-оос харахад эрчимт эмчилгээний тасагт ажиллаж байсан сувилагч нарын 92% нь шээлгүүр тавих ажилбарыг нэг өдөрт 1-5 үйлчлүүлэгчид гардан хийж гүйцэтгэж байсан бол, уян зүү тавих гардан ажилбарын хувьд: энгийн болон эрчимт эмчилгээний тасагт ажиллаж байсан сувилагч нарын 43-59.3% нь нэг өдөрт уян зүү тавьж уян зүүний арчилгааг үзүүлж байсан байна.

Хүснэгт 3. Эрчимт эмчилгээний тасагт хийгдэж байсан нэмэлт гардан үйлдэл

Үзүүлсэн тусламж	Өдөрт зондоор хооллож байсан хүний тоо	Өдөрт Төвийн венийн арчилгаа хийж байсан хүний тоо	Өдөрт SPAP эмчилгээ хийж байсан хүний тоо	Өдөрт угаалга хийж байсан хүний тоо	Өдөрт байрлал өөрчилж байсан хүний тоо
1-5 хүнд	59.3%	66.7%	81.5%	63.0%	77.8%
6-10 хүнд	7.4%	3.7%	3.7%	3.7%	3.7%
Тухайн үйлдэл хийгдээгүй	33.3%	29.6%	14.8%	33.3%	18.5%

Дээрх хүснэгтээс харахад зондоор хооллож байсан үйлчлүүлэгч 59.3%, төвийн венийн асаргаа сувилгаа 66.7% SPAP эмчилгээ 81.5%, өдөрт хүнд хүний угаалга 63%, хүнд үйлчлүүлэгчийн байрлал солих 77.8% тус тус эзэлж байна. Үүнийг дүгнэхэд: Сувилагчийн ажлын ачаалал их байгаа нь улаан бүсэд ч давтагдсаар байна.




Зураг 1. Нэг өдөрт 5 шатлалаар сувилж байсан үйлчлүүлэгч

Нэг өдөрт 45% нь11-16 үйлчлүүлэгчид таван шатлалаар сувилгаа үзүүлж байсан нь мөн л ажлын ачаалал их байна.

Хүснэгт 4. Хийгдэж байсан тарилгын төрөл


Үзүүлсэн тусламж	Арьсан дорх тариа		Булчин тариа		Судас		Дусал	
	Энгийн	Эрчимт	Энгийн	Эрчимт	Энгийн	Эрчимт	Энгийн	Эрчимт
5-15	35%	59.3%		7.4%				18.5% Цус плазм 44.4%
16-25	58.3%	40.7%		7.4%				44.4%
26-35	3.3%			29.6%				37%
36-45	3.3%			55.6%		11%	3.4	
46-55			13.3%		8.4%	33.3%	21.6	
55-65			10%		15%	54.9%	21.7	
66-75			31.7%		40%	3.7%	35	
75-с дээш			45%		36.6%		18.3	

Дээрх хүснэгтээс харахад арьсан дорх тариа энгийн тасаг 58.3%, эрчимт тасаг 59.3%, булчин тариа энгийн тасаг 45%, эрчимт эмчилгээний тасаг 55.6%, судас тариа энгийн тасагт 40%, эрчимт тасагт 54.9%, дусал тариа энгийн тасагт 35%, эрчимт эмчилгээний тасагт 44.4% хийгдэж байсан байна.




Зураг 2. Улаан бүсэд ажиллаж байх хугацаанд биед илэрдэг зовиурууд

Улаан бүсэд ажиллаж байх хугацаанд биед болон сэтгэлзүйд илэрдэг шинжүүдийг авч үзвэл: ядрах-92%, толгой өвдөх 63%-д нь илэрч байсан нь ажлын ачаалал ихтэй гэж үзэж байна.



Зураг 3. Улаан бүсэд ажиллаж байх хугацаанд илрэх сэтгэл зүйн өөрчлөлтүүд

Дээрх зургаас харахад айх түгших 81.5%, ар гэртээ санаа зовох 59.3%, хамгаалах хувцастай олон цаг ажиллах 74%, хэцүү үйлчлүүлэгч 89%-ийг эзэлж байгаа нь ажлын ачаалал ихээс сэтгэл зүйн талын өөрчлөлтүүд илэрсэн гэж үзэхээр байна.



Зураг 4. Хамгийн их ядрааж урам хугалж байсан асуудал

Олон үйлчлүүлэгчтэй байх, ажлын ачаалал их, хамгаалалтын хувцастай олон цагаар ажиллах, хэцүү үйлчлүүлэгч зэрэг нь 56-89% гарсан нь сувилагч нарыг хамгийн их ядрааж урмыг хугалж байжээ.

Хүснэгт 5. Энгийн тасагт ажиллахад ядрах болон урам хугарахад нөлөөлж байсан хүчин зүйлсийн хамаарал

Үзүүлэлт	Spearman's rho	Sig (2-tailed)
Үе мөч өвдөх	.354**	.006
Даралт ихдэх	.394**	.002
Уур уцаартай болох	.311*	.016
Ар гэртээ санаа зовох	.289*	.025
Анхаарал төвлөрөхгүй байх	.271*	.035
Уур уцаартай болох	.369**	.004
Ажлын ачаалал их байх	.411**	.001

Дээрх хүснэгтээс харахад үе мөч өвдөх, даралт ихдэх хоёр нь хоорондоо дунд хүчтэй хамааралтай, Р утга нь 0.002-0.006 статистик ач холбогдолтой гарч байна. Мөн уур уцаартай болох ажлын ачаалал хоёр нь хоорондоо дунд хүчтэй хамааралтай, Р утга нь 0.001-0.004 статистик ач холбогдолтой гарч байна. Өөрөөр хэлбэл ажлын ачаалал их байгаа нь уур уцаартай болоход нөлөөлж байгаа нь судалгааны үзүүлэлтүүдээс батлагдаж байна.

Хүснэгт 6. Эрчимт эмчилгээний тасагт ажиллахад ядрах болон урам хугарахад нөлөөлж байсан хүчин зүйлсийн хамаарал

Үзүүлэлт	Spearman's rho	Sig (2-tailed)
Айх түгших	.593**	.002
Толгой өвдөх	.472*	.013
Ядрах	.593**	.002
Хэцүү үйлчлүүлэгч	.693**	.000

Дээрх хүснэгтээс харахад ядрах хэцүү үйлчлүүлэгч хоорондоо шууд хүчтэй хамааралтай Р утга нь 0.001-0.002 статистик ач холбогдолтой гарч байна. Өөрөөр хэлбэл хэцүү үйлчлүүлэгч их байх тусам сувилагчдыг илүү их ядрахад нөлөөлж байна.

Хэлцэмж: Судлаач Д.Ариунаагийн "Короновирусын халдварын үеийн эрчимт эмчилгээний сувилагчийн ажлын ачаалалын судалсан нь" судалгаанд Хэцүү үйлчлүүлэгч Олон үйлчлүүлэгч 2 хоорондоо шууд хүчтэй хамааралтай Р утга мөн ач холбогдолтой гарч байгаа. Хэцүү үйлчлүүлэгч ажлын ачаалал 2 мөн шууд хүчтэй хамааралтай Р утга мөн ач холбогдолтой гарч байгаа. Өөрөөр хэлбэл хамгийн их ядрааж, урам хугарахад хэцүү үйлчлүүлэгч, ажлын ачаалал, битүү хувцас өмссөн, улаан бүсэд олон цагаар байх зэрэг нь шууд хүчтэй хамааралтай нөлөөлж байна гэж үзсэн байгаа нь бидний судалгаатай адил төстэй гарч байна.

Lucchini нарын (2020) судалгаагаар ковидын үеэрх эрчимт эмчилгээний тасгийн өвчтөнүүдтэй

ажилласан сувилахуйн ачаалал 33% нэмэгдсэн бол Bruyneel (2020) нарын судалгаагаар ажлын ачаалал 20% нэмэгдсэн ялангуяа шөнийн ээлжинд илүү их ачаалалтай ажилласан гэж гарсан нь бидний судалгаатай ойролцоо байна.

Дүгнэлт:

1. Сувилагч, тусгай мэргэжилтэнүүд улаан бүсэд олон удаагийн дамтамжтайгаар удаа дараалан орж ажиллаж байсан бөгөөд ажиллах хугцаандаа улаан бүс рүү хамгаалалтын хувцас хэрэгсэлтэй олон цагаар сувилахуйн тусламж үйлчилгээг үзүүлж байсан байна.
2. Энгийн болон эрчимт эмчилгээний тасгийн сувилагч нар ажлын цагийнхаа дийлэнх хувийг тариа тарилга, эмчилгээний хуудас, сувилахуйн түүх хөтлөлтөнд асаргаа сувилгаанд хийхэд зарцуулсан байна.
3. Улаан бүсэд ажиллаж буй сувилагч нарын ихэнх хувь нь толгой өвдөх, ядрах ар гэртээ санаа зовох, даралт ихсэх, хэцүү үйлчлүүлэгчтэй ажиллах зэрэг нь эерэг дунд зэргийн хамааралтай байгаа нь тогтоогдсон.

Ном зүй:

1. *Д.Мөнхцэцэг, Э. Ган-Эрдэнэ, Д.Гүндэгмаа "Сувилагч нарын ажлын ачаалал сувилахуйн тусламж үйлчилгээний чанарт нөлөөлөх нь" Сувилахуйн эрдмийн чуулган 2022 х 100*
2. *Нандинцэцэг Пунсалмаа Г.Нансалмаа, Б. Цогзолмаа "Мөнгөн гүүр эмнэлгийн хэвтэн эмчлүүлэх тасгуудын сувилагч нарын ажлын ачаалалд үнэлгээ өгөх" Эрдмийн чуулган 2022 х 71-72*
3. *https://jcp.bmj.com/content/74/10/673 2022.05.06.*
4. *https://doi.org/10.3346/jkms.2022.37.e49 jkms.org "Workload of healthcare Workers During the Covid-19 Outbreak in Korea; A.Natoinwide Survey*
5. *https://pubmed.ncbi.nlm.nih.gov/33306437/ 2022.05.06.*
6. *Ө.Ганчимэг. SPSS программд суралцах гарын авлага. УБ. 2009. Х 45*
7. *Д.Даваалхам Эпидмиологийн үндэс. ДЭМБ англи хэлнээс орчуулсан бүтээл. УБ., 2017. Х117-120.*
8. *Ц.Басбиш. Судалгааны статистик боловсруулалт. УБ.2020. Х 61-69*

Workload of frontline nurses and health professionals during COVID-19 pandemic

Mandalsaikhan Ch[1], Tumenjargal J[2], Gantuya O[2], Munkhjargal O[1], Zandarmaa Kh[1]

[1]Govi-Altai Medical school. MNUMS
[2]Govi-Altai Hospital
E-mail: mandalsaikhan@mnums.edu.mn, Tel: +976-99747829

Background: In March 2020 coronavirus infection was reported in Mongolia, the infection outbreak started in November and as of 6 April 2022, there had been 919.625 confirmed cases.The research "Impact of nursing workload on quality of patient care" showed that 85% of nurses experience a higher workload than ever before there was not sufficient time for performing nursing care duties due to the high number of patients per nurse. Moreover, caring for critically ill patients adversely affects nursing care quality.[1] A Nationwide Survey in Korea showed that in the ward for COVID-19 patients, nurses did duties other than their general duties: medical equipment management (80.0%), cleaning and disinfection of hospital rooms and beds (66.7%), transfer of patient specimens (33.3%), and meal delivery and feeding assistance of patients (26.7%).[6] During the Covid -19 pandemic, doctors and nurses worked in Covid-19 wards with an average duration of 10-14 days with a high workload and a shortage of human resources worldwide. Thus, we aimed to explore the workload of nursing staff and other health workers caring for patients with Covid-19.

Aim: To investigate and evaluate the workload of nurses worked in inpatient wards during the Covid-19 pandemic at the General hospital of Govi-Altai province

Materials and Methods: We involved 87 nurses and midwives who worked in Covid -19 departments of the General hospital of Govi-Altai province in the study. An analytical cross-sectional study design was utilized. The data analysis was done using SPSS version 21. The Kolmogorov–Smirnov test was used to determine data distribution and the statistical dependence was calculated by Spearman's correlation coefficient.

Results: As regards the gender and professions of the study participants, 93.1% were females, 6.9% were males, the majority were nurses (87.4%) and 12.6% were midwives. 57% of study participants were infected once, 13%-twice and 24% didn't get an infection while working in Covid-19 wards. In terms of the frequency of working in Covid 19 wards was 1-5 times. When the study participants were asked what was the reason for working in Covid-19 wards they responded that because of arranged shifts (34%), the organization's decision (48%), and their desires(18%). The study revealed that while the average number of patients in usual wards was more than 25 daily, the intensive care units had over 20 patients. In terms of nursing care procedures: administering medications was (71%) for 17-24 patients in the intensive care unit and usual wards' was (63%)for more than 25 patients. Inserting urinary catheter was performed for 1-5 patients (92%) and intravenous cannulation and its care in usual wards-55% and 59.3% in the intensive care unit respectively. Regarding the nursing procedures, the subcutaneous shot was 58.3% in usual wards and 59.3% in the intensive care unit, and intramuscular injection -was 45% in usual wards while it was 54.9% in ICU. Infusion procedure was 35% in usual wards and 44.4% in the ICU. The physical and mental impacts nurses faced while working in Covid 19 wards were the following: fatigue-92%, headache-63%, fear-81.5%, worrying about family- 59.3%, working long hours with personal protective equipment-74%, and handling difficult patients- 89% respectively.

Conclusion:

1. Nurses and other health workers in Covid-19 wards worked with high frequency of shifts wearing personal protective equipment for longer hours.
2. Nurses of Intensive Care and usual Covid-19 wards spent most of their working hours for giving injections ,performing nursing care and for filling in treatment and nursing report sheet.
3. Our study findings showed that most of the nurses who were working in Covid-19 wards experienced health crisis including headache, fatigue, worrying family members, hypertension, and handling with difficult patients which indicated strong positive correlations.Moreover,they faced many challenges including excessive workload, lack of protective equipment, psychological problems, fear, isolation in personal and family life, and lack of support in the workplace.

Keywords: Nursing care, manual action, psychology